



Бидэнд #ДажгүйЦэвэрлэгээнийНөхцөлүүдХэрэгтэй

Буудлын цэвэрлэгч байна гэдэг нь биеийн хүч шаардсан ба стресстэй ажил юм. Түүнээс гадна олон хүний ажлын нөхцөлүүд нь баталгагүй байдаг ба ачаалал ихтэй ажилладаг байна. HRF (Буудал - рестораны үйлдвэрчний эвлэл)-с хурцадмал байгаа асуудалуудын талаарх 7 хоногийн аян зохион байгуулна.

Тиймээс энэ мэдээллийг нийгмийн харилцааны цахим сувгуудаар тарааж туслана уу. Энэ цаасны нүүрэн талын зургийг авч цахим шуудангаар тараагаарай. Ерөнхий сайд үүнийг тараасан ба цэврэлгээний ажилтнууд мөн үүнийг тарааж байгаа. Чи ч мөн үүнийг хий! Бидний хаштаг бол **#schystastädvillkor**.

Энэхүү аян нь дэлхийн нийтийг хамарсан үйл ажилгааны нэг хэсэг нь болж байгаа ба манай салбарын төв болох IUL- ээр дамжигдан хэрэгжиж байгаа юм. Олон улсын хэмжээнд аяныг түгээх бол **#fairhousekeeping** гэсэн хаштагыг ашиглаарай.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.hrf.net сайтаас олж авна уу.

Доорхи зүйлүүдийг та ажилын байран дээрээ хийх болно:

- HRF (Буудал - рестораны үйлдвэрчний эвлэл) -д гишүүнээр элсээд, хамт ажилладаг ажилын хамт олноо ч мөн элсүүлээрэй. Бид олуулаа байж бидний нөлөөлөх чадвар ихсэх болно.
- Ажилын ачаалал их байсан ч завсарлага ав. Ажиллах эрч хүчтэй болохын тулд биед амралт хэрэгтэй.
- Хийж буй ажил хэтэрхий хүнд эсвэл ачаалалтай санагдвал түүнийгээ даргадаа хэлж бай. Хөдөлмөрлөх орчины тухай хуулийн дагуу ажилчдын ажиллах нөхцөл нь тухайн хүний ачаалал даах чадвартай дүйцсэн байх ёстой.
- Ажлынхаа нөхцөл байдалдаа чи өөрөө нөлөөлөх эрхтэй. Үүнийг ажил олгогчтойгоо (даргатайгаа) зөвшилцөх байдлаар хэрэгжүүлнэ. Үйлдвэрчний эвлэлийн ерөнхий мөрдлөгөтэй байгууллага бүр ажилчидтайгаа зөвшилцөх үүрэгтэй байдаг.
- Бид ажилын байранд учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх аргачиллаа сайжируулах хэрэгтэй.

Дэлгэрэнгүй мэдээллийг alltomstad.se орж уншин уу.

JAG TAR STÄLLNING FÖR

#schystastädvillkor

